



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 25 өдөр

Дугаар

9/240

Улаанбаатар хот

Улаанбурхан өвчний эсрэг
дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлэх
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1, 11.2.4, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.5 дахь хэсэг, Монгол Улсын Шадар сайдын "Журам шинэчлэн батлах тухай" 28 дугаар тушаал, Улсын онцгой комиссын 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр тогтоол, 2025 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 02 дугаар Хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн салбарт өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбоотой Улаанбурхан өвчний эсрэг дархлаажуулалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн дархлаажуулалтыг зохион байгуулж, Улаанбурхан, гахайн хавдар, улаануудын эсрэг товллын дархлаажуулалтаас хоцорсон 15 хүртэлх насны хүүхдүүдийн нөхөн дархлаажуулалтыг эрчимжүүлж, өвчний нөхцөл байдал, дархлаажуулалтын явцын мэдээллийг 7 хоног тутамд танилцуулж ажиллахыг Чингэлтэй нэгдсэн эмнэлгийн захирал (Х.Ганцэцэг), Өрхийн эрүүл мэндийн дарга нарт, дэмжлэг үзүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс (Л.Баярмаа), 1-24 дүгээр хороодын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Журмын дагуу 7 хоног тутамд эрсдэлийн үнэлгээ хийж, идэвхжилийн зэрэгт тохирсон хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Чингэлтэй нэгдсэн эмнэлэг (Х.Ганцэцэг), Өрхийн эрүүл мэндийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Улаанбурхан өвчний хариу арга хэмжээ, дархлаажуулалтын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (О.Батмөнх)-т зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ

1525010639